



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 750,750,000.00 /долоон зуун тавин сая долоон зуун тавин мянга/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 сарын 29-ний өдрийн
254 дугаар тогтоолын хавсралт



“НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр /регистрийн дугаар/	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөгөөр/	Эзлэх хувь	Нэгж хувьцааны үнэ	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,143 төгрөгөөр/	Эзлэх хувь
1	"Эф Эс Си Өү" ХХК /РД-5145155/	5,250,000	5,250,000,000.00	100%	143	750,750,000.00	-	5,250,000	6,000,750,000.00	100%
	Нийт	5,250,000	5,250,000,000.00	100%	143	750,750,000.00		5,250,000	6,000,750,000.00	100%